



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 108

Номгон

“Сайн багш” аймгийн дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Сайн багш” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д ДААЛГАХ нь:

2.1 Аймгийн төвийн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарыг сэлгэн ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлэсүгэй.

2.2 Жил бүр аймгийн төсөвт уул уурхайгаас орох орлогын 10 хувийг боловсролын салбарт зарцуулсугай.


2.3. Дэд хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117255



**“САЙН БАГШ” АЙМГИЙН  
ДЭД ХӨТӨЛБӨР**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.12-т “САЙН БАГШ” хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан.

Аймгийн Засаг даргын энэхүү санаачилга нь багш нарыг хөгжүүлэх, сургалтын чанар үр дүнг сайжруулах бодит бололцоо, дэмжлэг гэж үзээд боловсролын чанарт үр нөлөө өгөхөөр хэрэгжүүлэх шаардлага байна.

Дэлхий нийтээрээ “Багш” мэргэжлийн боловсролд тавьж буй шаардлагыг хангаж, боловсролын бодлогын шинэчлэл, өөрчлөлтийг мэдэрч түргэн дасан зохицож ажиллах чадварт багш нар суралцах хэрэгцээ бий болсон.

2013 онд шинэчлэгдсэн багш нарын мэргэжил дээшлүүлэх журмаар БМДИ 1, 5, 10 дахь жилдээ, БСУГ 2, 3, 4 дэх жилдээ багшилж байгаа багш нарыг сургалтад хамруулж байхаар журамласнаар БСУГ-аас багш нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх үйл ажиллагаа явуулах эрх зүйн болон төсөв санхүүгийн бололцоогүй болсон. Энэ асуудлыг орон нутагтаа шийдэх болон, орон нутгийнхаа боловсролын хөгжилд үр нөлөө үзүүлэх тогтвортой хандлага бүрдүүлэхэд чиглүүлж, багш нарыг хөгжүүлэх аймгийн нэгдсэн бодлогыг “Сайн багш хөтөлбөр”-т тусгаж байна. .

Хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго: Багш нарын сургалтын процессийг шинжлэх ухааны үндэстэй жолоодох, суралцагчдын сурлага, хөгжил, төлөвшлийн ахиц амжилтыг дэмжсэн үйл ажиллагаагаа явуулах чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагаандаа хариуцлагатай, сэтгэлтэй хандах хандлагатай болгоход оршино.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээний товлосон зорилт

1. Багш нарын “Багш бол тухайн салбарын тэргүүлэх мэргэжилтэн-судлаач, сэтгэл зүйч-дидактикч-менежер байна” гэсэн дэлхийн хэмжээнд тавьж байгаа шаардлагыг хангаж ажиллах мэдлэг чадварыг дээшлүүлэх
2. Багш багшлах ажилдаа чин сэтгэлээсээ, хариуцлагатай, ухамсартай хандаж ажиллах сэтгэлгээ, хандлага төлөвшүүлэх
3. Багш сайн ажиллах, өөрийгөө хөгжүүлэхэд нь үзүүлэх төр захиргааны байгууллагын “дэмжлэг” ба “туслалцааг” тодорхойлж, эрх зүйн зохицуулалттай болгох
4. Аймгийн хэмжээнд “Сайн багш”-ийг тодруулдаг оновчтой арга зүйг тогтоох

5. Багшийн амжилт олон нийтэд мэдээлэгдэх бололцоо бүрдүүлэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

1. Хөтөлбөрийг аймгийн засаг даргын ивээл дор хэрэгжүүлэх.
2. Багшийн өөрийгөө хөгжүүлэх, сайн ажиллах сэтгэл, зүтгэлд суурилах.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа боловсролын тухай хууль, болон холбогдох эрх зүйн ба бодлогын баримт бичгүүд, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй нийцсэн байхаас гадна багш нарын эрэлт хэрэгцээнд үндэслэсэн, бодитой, үр дүнтэй туслалцаа, дэмжлэг байх.
4. Хөтөлбөрийг тогтвортой хадгалагдах үр нөлөө бүхий байхад чиглүүлж хэрэгжүүлэх
5. Хөтөлбөрийн хэрэгжилт судалгаанд үндэслэх, үр дүнг тооцох, засаж сайжруулах уян хатан чанартай байх

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

- 1.1. Багшид тавигдах шаардлагын чиглэл бүрийн хүрээнд эзэмшсэн байх мэдлэг, ойлголт, чадварын хүрээг тогтоох
- 1.2. Багшийн мэдлэг боловсролоо дээшлүүлэх эрэлт хэрэгцээний судалгааг жил бүр явуулах
- 1.3. Багшид тавигдах шаардлагын чиглэл тус бүрээр сургалтын хөтөлбөр модуль боловсруулж, зорилгын ба түвшний ялгаатай сургалтыг жил бүр зохион байгуулах
- 1.4. Багш нарыг бие даан уншиж судлах шаардлагатай ном гарын авлагаар хангах
- 1.5. Багш нарт боловсрол судлалын мэдлэгээ хэрэглээ болгох арга зүйд сургах төлөвлөгөөт болон захиалгат зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх
- 1.6. Багш нарт зөвлөн туслах мэдээлэл харилцааны технологид суурилсан үйлчилгээг бий болгох

Хоёрдугаар зорилтын хүрээнд

- 2.1. Багш нараас мэргэшлийн шалгалт авах, мэргэжлийн шалгаруулалт явуулах журам гаргаж хэрэгжүүлэх
- 2.2. Багшийг ажлын үр дүнгээр урамшуулах, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгож журамлах
- 2.3. Багш нарын нэр хүндийг өсгөх, тэдний мэргэжил, мэргэшлийн өсөлт хөгжлийг тооцон үнэлэх арга аргачлал боловсруулж, сум орон нутагт мөрдөж, хэрэгжүүлэх
- 2.4. Өөрийн үйл ажиллагаандаа хяналт шинжилгээ хийх арга зүйд багш нарыг сургах
- 2.5. Багшийн ёс зүйн дүрмийг хангасан байдлыг багш бүрээр тооцдог болох
- 2.6. Багшийн хөдөлмөрийг үнэлэх үнэлгээг оновчтой болгох асуудлыг шийдэх

Гуравдугаар зорилтын хүрээнд:

3.1. “Сайн багш” шалгаруулах шалгуур, багш үйл ажиллагаагаа боловсронгуй болгоход нь үзүүлэх “дэмжлэг” ба “туслалцааг” аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж, хэрэгжүүлэх

3.2. Багш нарт шаардлагатай туслалцаа үзүүлэх үйлчилгээг тухайн жилд нийт багш нарын 50-иас доошгүй хувийг хамруулах, шаардлагатай багш нарт дэмжлэг үзүүлэх

3.3. Сургууль, цэцэрлэг, багш нарын дэвшилтэт ажил, арга зүйгээ бусдад таниулах, сурталчлах санаачилгыг дэмжих, хүсэлтийг биелүүлэх үйл ажиллагаа явуулах

3.4. Багшийн хөгжлийг дэмжсэн төсөлт болон захиалгат ажил үйлчилгээг жил бүр зарлаж, гүйцэтгүүлэх, үр дүнг тооцох

3.5. Сургалтын агуулгыг баяжуулах, хэрэглэгдэхүүн бэлтгэх гэх мэт тодорхой зорилго, чиглэлтэй дотоодын аялал, экскурс зохион байгуулах

3.6. Багш нар бие биеэсээ харилцан суралцах, туршлага судлах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг зохион байгуулах

3.7. Жил бүр 25-аас доошгүй багшийн зардлыг бүрэн хариуцаж гадаадын цэцэрлэг, сургууль, багш нарын туршлагыг судлуулах

3.8. Улс, олон улсын болон дэлхийн түвшний уралдаан тэмцээнд оролцоход нь багш сурагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, урамшуулах

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.1. “Сайн багш”-ийг тодруулах аргачлал боловсруулж мөрдөх, сайжруулж боловсронгуй болгох

4.2. “Сайн багш”-ийг тодруулахад суралцагч, сургууль, цэцэрлэгийн удирдлага, хамт олон, эцэг эх, төрийн ба олон нийтийн байгууллагын оролцоо, үүргийг баримт бичгээр тогтоох, таниулж сурталчлах

4.3. “Сайн багш”-ийг тодруулах асуулга судалгаа авах, хяналт шинжилгээ хийх ажлыг жил бүр сум орон нутгийн өөрийн болон төр захиргааны байгууллагын оролцоотой зохион байгуулах

4.4. Судалгаат хичээл арга хэмжээг сургууль, бүс, аймгийн хэмжээнд зохион байгуулах

4.5. “Сайн багш” тайлант ажлыг нэгж байгууллага, бүс, аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулах

4.6. Сурагчдын сурлагын түвшин тогтоох шалгалтыг жилд хоёр удаа авч, багшийн ажлын үнэлгээний үндсэн үзүүлэлт болгох

4.7. “Сайн багш”-ийг урамшуулах арга хэлбэрийг тогтоох, болзол гаргаж жил бүр дүгнэх

Тавдугаар зорилтын хүрээнд:

5.1. “Багшийн амжилт” мэдээллийн сантай болох

5.2. Багш улирал тутамд гаргасан амжилтаа мэдээллийн санд байршуулах

5.3. БСУГ багшийн мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт хийж, үнэлгээ өгөх

5.4. Багшийн ажлын ахиц амжилтыг баталгаажуулж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

### ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР, ГАРАХ ҮР ДҮН



1. Багш нар үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ, хариуцлагатай хандах сэтгэлгээ хандлагатай болох, түүнд нөлөөлдөг орон нутагтаа мөрдөх эрх зүйн орчин бүрдэнэ.

2. Багш нарын 50-иас доошгүй хувь нь тухайн салбарын мэргэжилтэн, судлаач-сэтгэл зүйч, дидактикч, менежер байх шаардлагыг бүрэн хангаж ажилладаг болсон байна.

3. “Багшийн амжилт” цахим сантай болж, үйл ажиллагаа нь тогтворжсон байна.

4. Аймгийн хэмжээнд “Сайн багш”-ийг тодруулдаг, үнэлдэг оновчтой арга зүй бий болсон байна.

5. Багш нар сургалтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй явуулах чадвартай болж, сэтгэлгээ ухамсар дээшилнэ.

6. Багш нар багшид тавих шаардлагыг хангаж ажилладаг болсноор сурлагын чанарт тодорхой ахиц гарсан байна.

7. Багшийг сайн ажиллахад нөлөөлөх нийгмийн нөлөөлөл сайжирч төр засгийн дэмжлэг тодорхой болсон байна.

8. Багш мэргэжлийн нэр хүнд өсч, нийгмийн сэтгэл зүйд эерэг хандлага бий болно.

### ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө гарган ажиллах

2. БСУГ хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах бөгөөд тухайн жилд хийх ажлыг байгууллагын ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3. Сум орон нутгийн төр захиргааны байгууллагын оролцоотой хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн оны аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилт болгон оруулах

4. Сургууль, цэцэрлэгүүдийн хичээлийн жилийн зорилго, зорилтод тусган хэрэгжүүлнэ.

5. Сургууль, цэцэрлэгүүд энэхүү хөтөлбөрт нийцсэн өөрийн онцлогтой зорилт дэвшүүлж, үйл ажиллагаа явуулна.

6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг 2 жил тутамд хийнэ.

### ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ХУГАЦАА

Уул уурхай эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдээс орон нутгийн төсөвт орох орлогын 10 хувь

2017 оноос 2020 он хүртэл